



ДУНДГОВЬ АЙМАГ
ГОВЬ-УГТААЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 16 өдөр

Дугаар 413

Хажуу шинэ ус

Зардал гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төсвийн тухай хуулийн 16.5.5, Ахмад настны тухай хуулийн 2 дугаар бүлгийн 12.1, 4 дүгээр бүлгийн 14 дүгээр зүйлийн 14.6, Ахмадуудыг харъяалуулах тухай Сумын Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 16-ний өдрийн А/05 тоот захирамж, Засаг даргын Тамгын газрын Хөдөлмөрийн дотоод журмын 9.3 дах заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. XVII дугаар жарны " Үзэсгэлэн болгогч " хэмээх усан туулай жилийн сар шинийн баярыг тохиолдуулан Засаг даргын Тамгын газрын харьяат ахмадуудад дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулахыг Засаг даргын Тамгын газрын архив бичиг хэргийн эрхлэгч (Э.Лайжинханд)-д үүрэг болгосугай.

2. Засаг даргын Тамгын газрын харьяат ахмад настайчуудын нэрсийг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

3. Байгууллагын харьяат ахмадуудад хүндэтгэл үзүүлэх 1,590,000 (Нэг сая таван зуун ерэн мянга) төгрөгийг Засаг даргын Тамгын газрын Ахмадын сангаас гарган зарцуулахыг нягтлан бодогч (У.Сүнжидмаа)-д зөвшөөрсүгэй.

Хавсралт хуудастай

ДАРГА



Н.ӨЛЗИЙТОГТОХ

482305003